

## ЗОРИЛТ 4: ТОГТОЛЦОО БҮРДҮҮЛЭХ, ТӨРИЙН БОДЛОГОД ТУСГАХ

Төслийн үйл ажиллагааны үр дүн болон туршлагыг Монгол талын хамтрагч байгууллагуудад танилцуулан үндэсний тогтолцоо бүрдүүлэх, бодлогод тусгах чиглэлээр ажиллана.



## ТӨСЛИЙН ЗОРИЛТОТ АЙМАГ / ДҮҮРЭГ


Нийслэлд Баянгол дүүрэг, орон нутгаас Хөвсгөл аймгийг төслийн туршилтын дүүрэг болон аймгаар сонгон үйл ажиллагаа явуулж байна.



Дээд тал: Монгол Улсын газрын зураг

Доод тал: УБ хотын газрын зураг

Нийслэлд 12 туршилтын сургууль ажиллаж байна.



## БИДЭНТЭЙ ХОЛБОО БАРИХ ХАЯГ

- БСШУСЯ, Засгийн газрын III байр, 212 тоот Утас: 976-9424-0702
- ХНХЯ-ны харьяа Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төв, 209 тоот Утас: 976-8634-0702  
Мэйл хаяг: [jica15start@gmail.com](mailto:jica15start@gmail.com)  
Веб хуудас:

<https://www.jica.go.jp/project/mongolian/mongolia/013/index.html>

Ерөнхий менежер /Боловсролын бодлого 1	Иший Тэцүяа
Менежер /Боловсролын бодлого 2	Сүзүки Саяака
Үнэлгээний хэрэглэгдэхүүн боловсруулалт 1	Хаяаши Акико
Үнэлгээний хэрэглэгдэхүүн боловсруулалт 2	Хашимото Соичи
Үнэлгээний хэрэглэгдэхүүн боловсруулалт 3	Канно Ацүши
Үнэлгээний тогтолцоо бий болгох дэмжлэг 1	Нишимүра Күмико
Үнэлгээний тогтолцоо бий болгох дэмжлэг 2	Сакүрай Рёохэй
Тусгай хэрэгцээт боловсрол 1	Оотомо Киёши
Тусгай хэрэгцээт боловсрол 2	Нэмото Юүки
Бичил төсөл, багш бэлтгэх, багшийн мэргэжил дээшлүүлэх сургалт 1	Үэхара Шооко
Багш бэлтгэх, БМД сургалт 2, сурталчилгаа, түгээн дэлгэрүүлэлт	Мория Кимика
Төслийн ажилтнууд	Г.Соёлгэрэл
	Х.Ганбаатар
	Г.Норжмаа
	Б.Нарангарав
	Т.Нямдаш
	Д.Одгэрэл
	Ц.Мөнхтуяа
	П.Батчимэг

2016 оны 2 дахь хэвлэл



## “ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭТ БОЛОВСРОЛ ШААРДЛАГАТАЙ ХҮҮХДЭД ҮЗҮҮЛЭХ ЭРҮҮЛ МЭНД, БОЛОВСРОЛ, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭГ САЙЖРУУЛАХ ТӨСӨЛ”



Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлж, тэдэнд үзүүлэх хөгжлийн дэмжлэг, боловсролын загварыг бий болгох зорилгоор үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байна.



Хэрэгжих хугацаа: 2015.08 сараас 2019.07 сар

## ЗОРИЛТ 1: ҮНЭЛГЭЭ, ХӨГЖЛИЙН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ТОГТОЛЦООГ БҮРДҮҮЛЭХ

Зорилтот аймаг/дүүрэгт холбогдох байгууллагын зүгээс ХБХ-ийн үнэлгээ, хөгжлийн дэмжлэг үзүүлэх чадавхийг бэхжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж байна. Одоогийн байдлаар хөгжлийн үнэлгээ, дэмжлэгт хамруулах сургалт, хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэхэд “Эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр”-ийг үр дүнтэй ашиглахад чиглэсэн үйл ажиллагаануудыг зохион байгуулаад байна.



Баянгол дүүрэгт хөгжлийн үнэлгээ, дэмжлэгт хамруулах сургалт зохион байгуулав.

(2016.03 сар)

Өмнөговь аймгийн ХБХЭМБНХ-ын Салбар комиссын үйл ажиллагаатай танилцав.

(2016.04 сар)



“Эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр”-ийг ашиглахад чиглэсэн семинар зохион байгуулав.

(2016.05 сар)

## ЗОРИЛТ 2: БОЛОВСРОЛЫН ЧАНАРЫГ ҮЗЭШЛҮҮЛЭХ

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд (ХБХ) чанартай боловсрол эзэмшүүлэх зорилгоор тусгай сургуулиудад “Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө”, “Ээлжит хичээлийн хөтөлбөр” боловсруулан судалгаат хичээл зохион байгуулж байна.

Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд гэртээ ойр ердийн сургуульд сурч байна. Тус төслийн хүрээнд тусгай сургуулиудын багш нараас ердийн сургалттай туршилтын сургуулиудын багш нарт зөвлөн туслах үйл ажиллагааг дэмжин ажиллаж байна.




Тусгай сургуулийн хичээл

(2015.09 сар)

Судалгаат хичээл

Хичээлийн дараах хэлэлцүүлэг (2016.03 сар)



Судалгаат хичээлээр тоо тоолж сургахад ашигласан хэрэглэгдэхүүн

(2016.03 сар)

☞ Тусгай сургууль нь утгын хувьд Японы тусгай дэмжлэгт сургуультай төстэй юм.

## ЗОРИЛТ 3: БИЧИЛ ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тусгай хэрэгцээнд нийцсэн сургалтын олон төрлийн арга хэлбэрийг туршин хэрэгжүүлж үр дүнг судлан, үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэх боломжтой загварыг бүрдүүлэх зорилгоор “Бичил төсөл” хэрэгжүүлж байна. 2016 онд нийслэл, орон нутгаас нийтдээ 35 төслийн санал хүлээн авч төслийн бичиг баримтыг судлан, төсөл ирүүлсэн эзэдтэй ярилцлага хийж сонгон шалгаруулснаар дараах 3 төсөл сонгогдон хэрэгжиж байна.

Байгууллага	Төслийн нэр, агуулга
“Монголын дауны холбоо” ТББ Нийслэлийн Хан-Уул дүүрэг	“Оюуны бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулах төсөл” 130-р сургуульд даунтай хүүхдийн тусгай анги байгуулж, биеийн тамир, дуу хөгжим, зургийн хичээлд ердийн ангийн хүүхдүүдтэй хамт суралцана.
Орхон аймгийн “Насан туршийн боловсрол олгох төв” Орхон аймгийн Баян-Өндөр сум	“Бид чадна” (Насан туршийн боловсрол олгох төвд ХБХ-ийг хүлээн авч сургах төсөл) Сургуульд сурч чадахгүй байгаа ХБХ-ийг албан бус боловсролд хамруулна. Төвд ирж суралцах боломжгүй хүүхдүүдэд гэрт нь явуулаар очиж боловсрол олгоно.
Хүүхдийн хөгжил, мэдээллийн “Учрал төв” ТББ Нийслэлийн 6 дүүрэг	ХБХ-дэд ээлтэй хүүхэд харах үйлчилгээг бэхжүүлэх төсөл” Хүүхдийн төлөө үндэсний газрын зөвшөөрлөөр гэртээ хүүхэд харах үйлчилгээг явуулж буй хүмүүст ХБХ-тэй ажиллах, тэдэнд багшлах арга зүй эзэмшүүлэх зорилгоор сургалтын модуль боловсруулна. Төслийнхөө зорилтот дүүргүүдэд сургалт зохион байгуулна.

Дээрх бичил төсөл хэрэгжүүлэх хугацаа: 2016.06 сараас 2017.05 сар хүртэл

